



**“ТАВАНТОЛГОЙН НҮҮРС АЧИХ ЛОГИСТИКИЙН ТӨВ”  
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

## Агуулга


БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, .....	4
НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	4
2.1 Төслийн талбайн байршил.....	4
2.2 Нийгэм эдийн засгийн ерөнхий төлөв .....	4
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН .....	6
ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....	6
3.1 Газрын гадарга, хэвлий.....	6
3.2 Агаарын чанар.....	6
3.3 Уур амьсгал.....	6
3.4 Гадаргын болон газрын доорх ус.....	6
3.5 Ургамлан нөмрөг.....	6
3.6 Амьтны аймаг.....	6
3.7 Тусгай хамгаалалттай газар нутаг.....	6
3.8 Дуу шуугиан.....	7
3.9 Нийгэм, эдийн засаг.....	7
3.10 Түүх, соёлын дурсгалт зүйлс: .....	7
3.11 Хаягдлын менежмент.....	7
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ .....	8
4.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ .....	8
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	10
БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	12
БҮЛЭГ 7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	13
БҮЛЭГ 8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	15
БҮЛЭГ 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....	16
БҮЛЭГ 10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ.....	18
УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	18
БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН .....	19
СУУГЧИД, ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ ..	19

## БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төв” нь экспортыг нэмэгдүүлэх, өртгийг бууруулах зорилгын хүрээнд Монгол Улсын засгийн газрын шийдвэрээр хэрэгжүүлж буй томоохон төсөл хөтөлбөр билээ. Энэхүү төсөл нь “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Үйлдвэрлэл, санхүү, эдийн засгийн төлөвлөлтийг богино, дунд хугацаанд тодорхойлж, компанийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор боловсруулсан 2021-2025 оны дунд хугацааны А6/20 Бизнес төлөвлөгөө, мөн компанийн Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ-/өөс баталсан 2020 оны хөрөнгө оруулалтын төсөв, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл юм.

Энэхүү Тавантолгой нүүрс ачих логиستيкийн төв төслийг барьж байгуулснаар “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн экспортыг нэмэгдүүлэх, тээврийн зардлыг бууруулах чухал ач холбогдолтой юм.

Энэхүү байгууламж нь ил уурхай, нүүрс баяжуулах үйлдвэр, төмөр замын төлөвлөгөөтэй уялдан хүчин чадлыг тооцож төслийг хэрэгжүүлэх 2 үе шаттай байхаар төлөвлөсөн бөгөөд 1-р үе шат 2022 оноос жилийн 20 сая.тн хүчин чадалтай, 2-р үе шат 2024 оноос хүчин чадлыг 35 сая.тн хүртэл өргөжүүлэх боломжтой.



Зураг 1 . Төслийн хамрах хүрээ


ТНАЛТ-ийн төслийг үндсэн 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Төсөл хэрэгжүүлэх үе шат нь Баруун цанхи, Зүүн цанхи, Бортээгийн ил уурхайн үйл ажиллагаа, вагон тээврийн төлөвлөлттэй уялдан хэрэгжинэ.

## БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### 2.1 Төслийн талбайн байршил

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн MV-016883 болон MV011943 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд буюу Зүүн Цанхийн уурхайн дэргэд байрлана.

*Зураг 2. Төслийн ерөнхий байршил*



*Хүснэгт 1. ТНАЛТ-ийн талбайн хэмжээ*

№	Аймаг, сум	Нутаг дэвсгэрийн хэмжээ, га
1	Цогтцэций	5492,63

### 2.2 Нийгэм эдийн засгийн ерөнхий төлөв

Монгол улсын хамгийн өмнөд хэсэгт, Өмнөговь аймгийн зүүн хэсэгт орших бөгөөд хойд талаараа дундговь аймгийн Өлзийт сумтай, бусад талаараа өөрийн аймгийн Цогт-Овоо, Манлай, Баян-Овоо, Ханхонгор, Ханбогд, Номгон сумдтай хиллэн, далайн түвшнээс дээш дунджаар 1200-1791 м-ийн өндөрлөгт орших бөгөөд бүхэлдээ говь цөлийн бүсэд хамаарна. Нийслэлээс 540 км, аймгийн төв Даланзадгадаас 100 км зайд, 724.6 мян.га нутаг дэвсгэртэй бөгөөд үүнээс бэлчээр 685.8 мян.га талбайг эзэлнэ. Цогтцэций сум нь засаг захиргааны Цагаан-Овоо, Сийрст, Билгэх гэсэн багуудтай, 72.5 хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй, Алтайн уулархаг мужид багтдаг. Засаг захиргааны нэгжийн хуваариар Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг Улаан нуурын хөндийд хамаарах бөгөөд Улаанбаатар хотоос өмнө зүгт 540 км, Өмнөговь аймгийн төв Даланзадгад хотоос зүүн зүгт 90 км, Цогтцэций сумын төвөөс баруун өмнө зүгт 16 км, Монгол-Хятадын хилээс 200 гаруй км, Оюу толгойн зэс, алтны ордоос 150 гаруй км-ийн зайд оршино. Засаг захиргааны анхан шатны нэгж болсон 4 багтай. Булаг, шанд, уул, толгод, говь хөндий, хоолой хосолсон байгалийн эрдэнэс баялгаар баян арвин баялаг нөөцтэй “Тавантолгой” нүүрсний орд зэргээр алдартай,

нутаг юм. Чулуун нүүрс, Гөлтгөнө, галд тэсвэртэй шавар, алт, зэс, хужир зэрэг эрдэс баялгаа хөрсөн дороо агуулснаас гадна эдийн засгийн голлох салбар нь мал аж ахуй бөгөөд сүүлийн жилүүдэд уул уурхай эрчимтэй хөгжиж түүнийг даган сум орон нутагт дэд бүтэц хөгжиж, хөгжил цэцэглэлтийн шинэ эрин үетэй зэрэгцэн хөгжих боломж бүрдсэн нутаг юм.

*Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан ерөнхий үзүүлэлт*

Сумын нэр	Нутаг дэвсгэрийн хэмжээ, км.кв Багийн тоо	Хүн амын тоо 2018	Өрхийн тоо 2018	Малчин өрх тоо 2018	Малын тоо
Цогтцэций	7246,4 км.кв. 4 багтай. Цагаан овоо,Сийрст баг	7692	2250	312	135026

Эх сурвалж: ҮСГ, [www.1212.mn](http://www.1212.mn)

**Хүн ам:** 2018 оны байдлаар Цогтцэций суманд 2550 өрхийн 7692 хүн амьдарч байна. Судалгаанаас үзэхэд төсөл хэрэгжүүлэх сум хүн амын тоо сүүлийн жилүүдэд өсөж ирсэн ба энэ нь уул уурхай, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтэц, зам харгуйтай шууд холбоотой гэж үзэж байна. Тухайлбал: 2005-2020 оноор сумын хүн амын тоонд харьцуулалт хийж үзэхэд Цогтцэций 2283 хүн амтай байсан бол 2018 онд Цогтцэций 236.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

**Эдийн засаг:** 2018 оны байдлаар аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлээс Цогтцэций сум гэхэд 888,811.77 сая төгрөг бүрдүүлж байгаа нь Тавантолгойн ордоос нүүрс олборлолттой шууд холбоотой юм. Түүнчлэн судалгаанд хамрагдсан сумдын эдийн засгийн голлох салбарын нэг нь хөдөө аж ахуй, ялангуяа мал аж ахуйн салбар юм. Тухайлбал: 2018 оныг 2005 онтой харьцуулахад Цогтцэций сумын нийт малын тоо 133.9 хувиар өсчээ.

## БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН

### ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Энэ бүлгийн зорилго нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт хэрэгжих “ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ийн “Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв төсөл” байгуулах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин болон нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг үнэлж, дүн шинжилгээ хийж, тодорхойлон тооцоход оршино.

**3.1 Газрын гадарга, хэвлий.** Төслийн барилгын ажлын үед шатах тослох материал алдагдах, хог хаягдлын менежментийг хангалтгүй хийснээс хог хаягдлаар бохирдох, газрын гадарга эвдрэлд орох зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй. Тус талбай нь хойноосоо урагш уртрагийн дагуу сунаж тогтсон учир хотгор гүдгэрийн хувьд дундаж өндөр, нам уулс, цав толгод, хөндий хотгор хосолсон бөгөөд ерөнхийдөө долгиорхог тэгш гадаргатай.

**3.2 Агаарын чанар.** Төсөлд ашиглах тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр түр зам, талбайгаас тоосжилт үүсэж агаарын чанарт нөлөөлж болзошгүй. Мөн төсөлд ашиглах техник хэрэгслүүдээс нүүрсхүчлийн хий, хүхэрлэг хий, азотын исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл ялгарч, агаарын чанарын найрлагад түр хугацаанд бага хэмжээгээр нөлөөлнө.

**3.3 Уур амьсгал.** Төслийн талбайд ашиглах техник хэрэгслүүдээс хүлэмжийн хийн гол бүрэлдэхүүн болох нүүрсхүчлийн хий ялгарч агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг бага хэмжээгээр нэмэгдүүлнэ.

**3.4 Гадаргын болон газрын доорх ус.** Төслийн талбайд ажиллах тээврийн хэрэгслүүдэд эвдрэл, гэмтэл гарсан үед болон ажилчдын санамсар болгоомжгүй байдал, байгалийн давагдашгүй хүчин зүйлээс гэнэтийн осол гарч шатах тослох материал асгарсан тохиолдолд хөрс бохирдож, улмаар хур тунадас орсон үед үерийн усаар дамжин гадаргын түр урсац болон газрын доорх усыг бохирдуулж болзошгүй.

**3.5 Ургамлан нөмрөг.** Төсөл хэрэгжүүлэх талбай, барилгын ажилд ашиглагдах түр зам, кемп байгуулах газрууд бүтээн байгуулалтын үед нөлөөлөлд өртөнө. Бүтээн байгуулалтын дараа “Нөхөн сэргээлт, орчны тохижуулалтын төлөвлөгөө”-ний дагуу нөлөөлөлд өртсөн талбай, газруудыг холбогдох стандартын дагуу нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

**3.6 Амьтны аймаг.** Төслийн үйл ажиллагааны улмаас амьтны аймагт дараах нөлөөлөл, үр дагаврууд бий болж болзошгүй. Төслийн үндсэн үйл ажиллагаа хөрс шүтэн амьдрагч мэрэгч амьтад, мөлхөгчид болон шавжийн зүйлийн бүрдэл, тоо толгойг бууруулах, амьдрах орчныг алдагдуулах сөрөг нөлөө үүсэх магадлалтай. Хөрсний эвдрэл, доройтол, орчны тоосжилтын улмаас ургамал идэшт амьтдын тоо толгой буурах нөлөөлөл гарч болзошгүй. Төслийг хэрэгжүүлэх явцад амьтдын амьдрах орчин өөрчлөгдөж, шинээр бий болсон орчинд тухайн нутагт өмнө нь тохиолдож байгаагүй, эсвэл тоо толгой нь цөөн байсан амьтад олноор шилжин суурьшиж болзошгүй тул амьтдын унаган амьдрах орчныг бүрдүүлэх, амьтны төрөл зүйлийг сэргээхэд анхаарах шаардлагатай.

**3.7 Тусгай хамгаалалттай газар нутаг.** Төслийн талбай нь дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, байгалийн дурсгалт газарт хамаарахгүй тул тэдгээр газруудад шууд нөлөөлөх сөрөг нөлөөлөл байхгүй байна.

**3.8 Дуу шуугиан.** Төслийн бүтээн байгуулалтын үед төслийн талбайд ажиллах тээврийн хэрэгслээс үүдэлтэй дуу шуугиан үүсч болзошгүй. Төслийн хэрэгжүүлэх талбайд дуу шуугианы хэмжилтийн хамгийн их утга нь 77.5 дБа, дундаж нь 53 дБа, хамгийн бага утга нь 39.2 дБа байна.

**3.9 Нийгэм, эдийн засаг.** Үйлдвэрийн бүс, овоолгын үйл ажиллагаанаа үүсэх тоосжилт төслийн талбайн ойролцоох нөлөөллийн бүсэд хамрагдах малчин өрх, байгаль орчинд нөлөөлөх магадлалтай.

**3.10 Түүх, соёлын дурсгалт зүйлс:** Төслийн талбай болон түүний ойр орчимд түүх, соёлын дурсгалт зүйлс өнөөгийн байдлаар тодорхойлогдоогүй байна. Энэхүү төсөл хэрэгжүүлэх явцад мэдэгдээгүй түүх дурсгалын зүйлс, булш, бунхан хиргисүүр, археологи, палеонтологийн зүйлс илрэх тохиолдолд түүх соёлын үнэт өвийг хамгаалах үүднээс үйл ажиллагаагаа зогсоож хамгаалалт гарган зохих хууль ёсны дагуу мэргэжлийн байгууллагад мэдэгдэх, улмаар тухайн газар нутгийг бүрэн хамгаалалтанд авах зэрэг арга хэмжээг авах шаардлагатай.

**3.11 Хаягдлын менежмент.** Түр кемп, төслийн талбайд ажиллаж буй ерөнхий болон туслан гүйцэтгэгч нарын үйл ажиллагаанаас аюултай болон ахуйн хог хаягдлууд үүсч санамсар болгоомжгүй байдлаас үүдэн хаягдал асгарч алдагдсанаас болж хүрээлэн буй орчныг бохирдуулж болзошгүй.

Төслийн барилга, байгууламжуудын үйл ажиллагааны үед бий болох хаягдал, тэдгээрийн устгал, зайлуулалтын улмаас байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллүүдийг хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх замаар үр ашигтай зохион байгуулж, бууруулж болно. Энэ нь төслийн байгаль орчны менежментийн чухал хэсэг болно.

## **БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ**

### **4.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ**

“Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төв” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын хүрээнд тухайн төслийн хэрэгжилтийн явцад буюу 2022-2026 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав.

Энэхүү төлөвлөгөөний зорилго нь тухайн төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, бохирдлоос сэргийлэх, ерөнхий үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийг төлөвлөх, хэрэгжилтийн үр дүнг тогтооход оршино. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдсэн.

Төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг бэлтгэл, барьж байгуулах болон ашиглалтын үе шатны батлагдсан төлөвлөгөөтэй уялдуулан жил бүрийн эхний улиралд багтаан боловсруулж батлуулна (А/618-журмын 2.15 дахь заалт).

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах зүйлсээс бүрдэнэ.

Үүнд:

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө;
2. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө;
3. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө;
4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө;
5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр;
6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө;
7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө;

Энэхүү бүтээн байгуулалтын төслийн 2023 онд хэрэгжүүлэх БОМТ-ний нийт зардал урьдчилсан байдлаар, гучин нэгэн сая далан таван мянган төгрөг болж байна. (31,075,000) (Хүснэгт 3)



Хүснэгт 3. 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

Д/д	Авах арга хэмжээ	Зардал, төгрөг
		2023 он
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1,700,000
2.	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	5,600,000
3.	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	8,625,000
4.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	10,450,000
5.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	3,100,000
6.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1,500,000
7.	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө	100,000
<b>2023 оны нийт зардал, төгрөг</b>		<b>31,075,000</b>

## БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтуудыг Монгол Улсын байгаль орчны багц хуулиудаар тавигдсан шаардлага, БОАЖЯ-ны 2019 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн ерөнхий үнэлгээний дүгнэлт, БОННУ-ний хүрээнд боловсруулсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, шаардлагуудыг үндэслэн тодорхойлов.

*Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө*

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
<b>1. АГААР ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР</b>								
Төслийн барилгын ажилд ашиглагдах машин механизм, дизель станцаас ялгаран гарах хорт хий орчны агаарыг бохирдуулах	Барилгын ажилд ашиглагдаж буй бүх төрлийн машин механизм, дизель станцад үзлэг оношилгоо засварыг тогтмол хийж, холбогдох стандартын шаардлагад нийцүүлэх	Төслийн талбай	ш	24	50,000	1,200,000	2023 онд Хуурайшилтын улиралд өдөр бүр бусад үед цаг уурын нөхцөлөөс хамаарна.	Агаарын тухай хууль 9, 11, 23-р зүйл MNS 4585:2007
Барилгын ажлын талбайгаас болон шороон замаас тоос дэгдэж хүрээлэн буй орчинд тархах	Зам, талбайг услах. Барилгын ажлын үед үүсэх тоосжилтыг дарахын тулд	Төслийн талбай	Үйл ажиллагааны зардалд тусгах				2022-2026 онд Хуурайшилтын улиралд өдөр бүр бусад үед цаг уурын нөхцөлөөс хамаарна	Агаарын тухай хууль 9, 11, 23-р зүйл MNS 4585:2007
<b>2. Хөрс ба ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр</b>								

Төслийн нөлөөгөөр орчны үржил шимт хөрс, ургамлан бүрхэвч бүхий талбай барилга байгууламж, хүнд даацын машин техникийн үйл ажиллагааны нөлөөнд өртөж, хөрсний элэгдэл, эвдрэл үүсэж ургамлан бүрхэвч сөрөг нөлөөлөлд өртөнө.	Төсөл хэрэгжүүлэх талбай, барилгын ажилд ашиглагдах шороон замуудын маршрутыг тогтоож тэмдэгжүүлэх	Төслийн талбайд ажилд ашиглагдах шороон замууд	ш	10	30,000	300,000	2023 онд (барилгын ажил дуустал жил бүр тодорхой төлөвлөгөөний дагуу арчилж тордох	“Газрын тухай” хууль 50 дугаар зүйл MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт.
<b>3. Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр</b>								
Усыг тооцоогүй ашигласнаас газрын доорх усны нөөц хомсдох	Барилгын ажилд ус авч ашиглах гүний худгыг тоолууржуулах	Худаг	ш	2	100,000	200,000	2023 онд (барилгын ажил дуустал улиралд 1 удаа баталгаажуулж байх)	MNS0900:2018-Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, авулгүй байдлын үнэлгээ.
<b>4. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр</b>								
Төслийн ажиллагаанаас амьтдын тоо толгой буурах, дайжих, амьдрах орчин нь устах, идэш тэжээл нь хомстохоос хамгаалах	Зэрлэг амьтдад ган, зудтай үед идэш тэжээл тавьж өгөх, усны эх үүсвэр гаргаж өгөх, нутгийн иргэд, байгаль хамгаалагчтай хамтран ажиллах	Цэций уул түүний ойр орчим	Удаа		Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах		2023 онд	Амьтны тухай хууль
<b>Нийт дүн</b>						<b>1,700,000</b>		

## БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт 5. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө*

Нөхөн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
Мод тарих	Говийн нөхцөлд тохирсон мод тарих	Ажиллагсадын түр сууц болон оффис орчим	ш	3000	200	600,000	2023 он	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Туузан дамжуургын суурийн буцаан дүүргэлтэлтийн ажилд ашигласан карьерын нөхөн сэргээх	Техникийн нөхөн сэргээлт	Ашиглаж дууссан карьеруудын ухашыг байгалийн зүй тогтолд ойртуулан хэлбэржүүлэх дүүргэлт болон тэгшлэлт хийх	га	1,000,000	5	5,000,000	2023 он	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль MNS 5915:2008 MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2008
<b>Нийт дүн</b>						<b>5,600,000</b>		

## БҮЛЭГ 7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт 7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө*

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
<b>Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр</b>								
Цаг агаарын гэнэтийн үзэгдлээс үйл ажиллагаа доголдох, зогсох	Цаг агаарын улирлын, сарын, 7 хоногийн, өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд тогтмол ашиглах	Төслийн талбай	Өдөр	-	365	Өмнөговь аймгийн Цаг уур орчны шинжилгээний газартай тохиролцох	2023 онд	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль
Гал түймрийн улмаас төслийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	Төслийн талбай	улирал/удаа	200,000	12	2,400,000	2023 онд	Галын аюулгүй байдлын тухай хууль
	Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу	Төслийн талбай	хүн/өдөр	50,000	5	250,000	Жил бүр 2023 онд	

	байрлуулж бэлэн байдлыг хангаж ажиллах							
<b>Дүн</b>						<b>2,650,000</b>		
<b>Үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр</b>								
Үйлдвэрлэлийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сэргээр нөлөөлөх	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих	Төслийн талбай	хүн/өдөр	12,500	430	5,375,000	2023 онд	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол хугацаанд гүйцэтгэх	Төслийн талбай	сар/удаа	50,000	12	600,000	2023 онд	
	Ажиллагсдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Төслийн талбайд ажиллах бүх ажилдан нар	Улирал/жил	-	135	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах	2023 онд	
<b>Нийт дүн</b>						<b>8,625,000</b>		

## БҮЛЭГ 8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө*

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
Ахуйн	Ахуйн гаралтай хог хаягдлыг ангилан ялгаж дахин ашиглах, зайлуулах арга хэмжээнүүдийг тодорхойлох	Төслийн бүх төрлийн байгууламжууд	Хүн/өдөр	30,000	215	6,450,000	2023 онд	Хог хаягдлын тухай хууль, БОАЖС-ын 2018 оны 11 дүгээр сарын 19-ний Өдрийн А/445 дугаар тушаал, БОАЖС-ын 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/443 дугаар тушаал, БОАЖС-ын 2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/18 дугаар тушаал
Үйлдвэрийн	Үйлдвэрлэлийн гаралтай хаягдлыг ил задгай хаяхгүй байх, зориулалтын битүү саванд ангилан ялгаж, хадгалах дахин ашиглах болон үйлдвэрлэгчид нийлүүлэх арга хэмжээнүүдийг тодорхойлох	Төслийн бүх төрлийн байгууламжууд					2023 онд	
Тээвэрлэх үйлчилгээний хөлс		Төслийн бүх төрлийн байгууламжууд				4,000,000	2023 онд	
<b>Нийт дүн</b>						<b>10,450,000</b>		

## БҮЛЭГ 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт ба арга, аргачлал
1	2	3	4	5	6	7	8
<b>1. Агаарын чанар</b>							
Ялгарах бохирдуулагчид: SO <sub>2</sub> , CO, NO <sub>2</sub>	Төслийн талбайд 2 байршилд	Жилд 2 удаа дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө (4,10 сард)	2 удаа (Нийт 4 ш дээж)	200,000	800,000	Үйл ажиллагаа жигдэрсэн үед хийлгэх	MNS 4585:2016), MNS 5919:2008  MNS 5013 :2001  MNS ISO 4221: 2002 MNS 5365:2004
O <sub>2</sub> , CO <sub>2</sub> , CO, NO, NO <sub>2</sub> ,SO <sub>2</sub> , CxHy/HC, H <sub>2</sub> S, утааны хэм оС, утааны агаарын даралт, утааны хурд м/с	Төслийн ажилд ашиглагдаж байгаа дизель цахилгаан үүсгүүрүүдээс 2-ыг сонгож ялгаруулж буй утаанд нь хэмжилт хийх	Жилд 2 удаа дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө (4,10 сард)	2 удаа (Нийт 4 ш дээж)	100,000	400,000	Үйл ажиллагаа жигдэрсэн үед хийлгэх	
Тоосны хэмжилт: PM <sub>10</sub> ,PM <sub>2.5</sub> Тоосны чөлөөтУналт, Тоосны найрлага, бүтэц, тоосны тархалт	Төслийн талбайд /овоолго үүсгэх хэсэгт 2 байршилд/	Жилд 2 удаа дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө (4,10 сард)	2 удаа (Нийт 4 ш дээж)	200,000	800,000	Үйл ажиллагаа жигдэрсэн үед хийлгэх	
<b>2. Газрын доорх ус</b>							



Химийн ерөнхий чанар рН, нийт ууссан хатуу бодисын хэмжээ, нийт хатуулаг, цахилгаан дамжуулах чанар, усны түвшин	Төсөлд ашиглагдах худгуудаас дээж авах	Жилд 2 удаа дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө.(5, 10 сард)	2 удаа (Нийт 2 ш дээж)	100,000	200,000	Үйл ажиллагаа жигдэрсэн үед хийлгэх	MNS 0900:2005 (MNS6148:2010) MNS (ISO) 4867:1999 MNS (ISO) 5667 11:2000 MNS (ISO) 56671:2002
<b>3. Хөрсөн бүрхэвч</b>							
Хөрсний өнгөн болон дээд үе давхаргын элсжилт, чулуужилт, тоосжилт зэрэг морфологи тогтцын ерөнхий төлөв байдалд шинжилгээ хийх	Төслийн талбайн ойролцоо нэг байршилд нөлөөлөлд өртөөгүй талбайд	Жилд 2 удаа дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө. (5, 10 сард)	2 удаа (Нийт 6 ш дээж)	150,000	900,000	Үйл ажиллагаа жигдэрсэн үед хийлгэх	MNS:3297:1991 MNS:2305:1994 MNS:3298:1991
<b>Нийт дүн</b>					<b>3,100,000</b>		

**БҮЛЭГ 10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгөөр үйл ажиллагаа явуулах, төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах үүргийг төсөл хэрэгжүүлэгчийн удирдлага хүлээнэ. Зохион байгуулалтын арга хэмжээний зардлыг дор тусгав.

*Хүснэгт 10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө ба зардал*

<b>Хэрэгжүүлэх арга хэмжээ</b>	<b>Арга хэмжээний цар, хэмжээ</b>	<b>Нийт зардал, төг</b>	<b>Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж</b>	<b>Хариуцах эзэн</b>
Туслан гүйцэтгэгч нарын Улаанбаатар хотод үзлэгт хамраагүй ажиллагсдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	Өмнөговь аймгийн нэгдсэн эмнэлэг болон сумдын эрүүл мэндийн төв	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах	Жил бүр	ЗУГ, Эмч сувилагч нар
Тухайн жилийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрх бүхий байгууллагад тайлагнах	Төслийн талбай	1,500,000	2023 онд жил бүрийн 11-12 дугаар сард	Байгаль орчны асуудал хариуцсан нэгж
Жил бүрийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах	Төслийн талбай		Жил бүрийн эхний улиралд багтаах	Байгаль орчны асуудал хариуцсан нэгж
<b>Нийт дүн</b>		<b>1,500,000</b>		

## БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН

### СУУГЧИД, ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ

“Тавантолгой төмөр зам” ХХК нь “Түүхий нүүрс ачих логистикийн төв байгуулах төсөл”-ийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар Өмнөговь аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлэх ба бүх шатны Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч нарт тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ. Мөн БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийнэ.

*Хүснэгт 11. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах хуваарь*

БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар	Зардал, төг
Өмнөговь аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар	БОМТ-ний тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлнэ.	БОМТ-ний хэрэгжилтийн тухай	Жил бүрийн 11-12 дугаар сард	БОМТ-ний хэрэгжилтийн тайланг баталгаажуулах.	Өмнөговь аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлнэ	-
Цогтцэций, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	БОМТ-ний тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, ИТХ-аар оруулж танилцуулах	БОМТ-ний хэрэгжилтийн тухай	Жил бүрийн 11-12 дугаар сард	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнаж олон нийтэд таниулж санал авах	Сумын төвд	100,000

Цагаан овоо багийн иргэдийн нийтийн хурал	БОМТ-ний тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж хүргүүлэх	БОМТ-ний хэрэгжилтийн тухай	Жил бүрийн 11-12 дугаар сард	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнаж олон нийтэд таниулж санал авах	Багийн төвд	-
<b>Нийт дүн</b>						<b>100,000</b>